

6. хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд нас барвал түүний оршуулгын зардалд нийгмийн даатгалын сангаас олгох оршуулгын тэтгэмжийн 75 хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн тусламж олгоно

Хөнгөлөлт авах хүсэлт гаргахдаа дараах бичиг баримтыг бүрдүүлнэ.

1. *хөнгөлөлт авахыг хүссэн өргөдөл;*
2. нас барсны гэрчилгээ;
3. оршуулгын тэтгэмж олгоогүй тухай аймаг, дүүргийн нийгмийн даатгал (суманд нийгмийн даатгалын байцаагч)-ын байгууллагын тодорхойлолт;
4. хөгжлийн бэрхшээлтэй байсныг гэрчлэх баримт;

16 насанд хүрээгүй хүүхдийн хөгжлийн бэрхшээлийг эрүүл мэндийн байгууллагын мэргэжлийн эмч нарын хяналтын комисс, 16 насанд хүрсэн иргэний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хэмжээг эмнэлэг хөдөлмөрийн магадлах комисс тус тус тогтооно.

Тусгай хэрэгцээт боловсрол олгох ясли, цэцэрлэг, бүх шатны сургууль, мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвд суралцах хүүхэд ба иргэнийг эрүүл мэндийн байгууллагын нарийн мэргэжлийн эмч нарын хяналтын комисс тодорхойлно.

**Лавлах утас: ХАХНХЯ 262686
НХҮЕГ 70127030, 70127040**



ХАХНХЯ



НХҮЕГ

**ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ
ХҮҮХДЭД ҮЗҮҮЛЭХ ТУСЛАМЖ,
ХӨНГӨЛӨЛТ**

/Иргэдийн гарын авлага /

**Улаанбаатар хот
2013 он**

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд үзүүлэх тусламж, хөнгөлөлт.

1. 18 хүртэлх насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн дотоод хийлгэсэн протезийн үнийг 2 жил тутам нэг удаа, худалдан авсан ортопед, тэргэнцэр тусгай хэрэгслийн үнийг 3 жил тутам нэг удаа 100 хувь нөхөн олгоно.

Хөнгөлөлт авах хүсэлт гаргахдаа дараахь бичиг баримтыг бүрдүүлнэ.

1. өргөдөл маягтын дагуу;
 2. протез, орпoted хийлгэх болон тусгай хэрэгсэл шаардлагатай тухай нарийн мэргэжлийн эмчийн тодорхойлолт;
 3. төрсний гэрчилгээ (16 насанд хүрсэн бол иргэний үнэмлэх) хуулбарын хамт;
 4. хөгжлийн бэрхшээлтэй иргэний үнэмлэх, хуулбарын хамт;
 5. протез, ортопед, тусгай хэрэгслийн төлбөр төлсөн баримт эсхүл нэхэмжлэл;
- 2.Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд болон түүний асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн цэцэрлэг, сургуульд ирж, очих унааны зардлыг жилд нэг удаа хөнгөлөх, эсхүл автобусаар үйлчилнэ.**

Хөнгөлөлт авах хүсэлт гаргахдаа дараах бичиг баримтыг бүрдүүлнэ.

1. *хөнгөлөлт авахыг хүссэн өргөдөл;*
2. *төрсний гэрчилгээ, (16 насанд хүрсэн бол иргэний үнэмлэх) хуулбарын хамт;*
3. цэцэрлэг, сургуульд хүргэж өгөх болон цэцэрлэг, сургуулиас авч гэрт нь хүргэж өгөх хүний иргэний үнэмлэх, хуулбарын хамт;

4. хүүхдийн хөгжлийн бэрхшээлийг тодорхойлсон эрүүл мэндийн байгууллагын мэргэжлийн эмч нарын хяналтын комиссын шийдвэр;

5. хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд нь сургууль, цэцэрлэгт суралцаж буйг тодорхойлсон сургууль, цэцэрлэгийн тодорхойлолт;

6. орон нутагт оршин суудаг хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд аймаг болон сумын төв, нийслэлд суралцахаар ирсэн бол тээврийн зардал төлсөн баримт эсхүл нэхэмжлэл.

3.Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн болон хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан иргэний нэг хүүхдийн цэцэрлэгийн хоолны зардлын төлбөрт хөнгөлөлт үзүүлнэ.

Хөнгөлөлт авах хүсэлт гаргахдаа дараах бичиг баримтыг бүрдүүлнэ.

1. *хөнгөлөлт авахыг хүссэн өргөдөл;*
- 2.16 насанд хүрээгүй хүүхдийн хөгжлийн бэрхшээлийг тогтоосон эрүүл мэндийн байгууллагын мэргэжлийн эмч нарын хяналтын комиссын шийдвэр;
3. хүүхдийн төрсний гэрчилгээ, хуулбарын хамт;
4. хүүхэд нь цэцэрлэгт хүмүүждэг тухай сургуулийн өмнөх боловсролын байгууллагын тодорхойлолт, нэхэмжлэл.

4. эмчилгээ сувилгаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд дотоодын рашаан сувилалд сувилуулбал нэг талын унааны зардал, эрхийн бичгийн үнийн 50 хувийг жилд нэг удаа нөхөн олгоно.

Хөнгөлөлт авах хүсэлт гаргахдаа дараах бичиг баримтыг бүрдүүлнэ.

3. *хөнгөлөлт авахыг хүссэн өргөдөл;*

4. *төрсний гэрчилгээ, (16 насанд хүрсэн бол иргэний үнэмлэх) хуулбарын хамт;*

3. 16 насанд хүрээгүй хүүхдийн хөгжлийн бэрхшээлийг тогтоосон эрүүл мэндийн байгууллагын мэргэжлийн эмч нарын хяналтын комиссын, 16 насанд хүрсэн иргэний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хэмжээг тогтоосон эмнэлэг, хөдөлмөрийн магадлах комиссын шийдвэр;

4. замын зардал төлсөн баримт эсхүл нэхэмжлэл;

5. рашаан сувилалд сувилуулсан эрхийн бичгийн үнэ төлсөн тухай санхүүгийн баримт эсхүл нэхэмжлэл;

6. эмчилгээ, сувилгаа шаардлагатай тухай эмнэлгийн байгууллагын дүгнэлт

5. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд нь хүүхдийн зусланд амарвал эрхийн бичгийн үнийн 50 хувийг жилд нэг удаа олгоно.

Хөнгөлөлт авах хүсэлт гаргахдаа дараах бичиг баримтыг бүрдүүлнэ.

1. *хөнгөлөлт авахыг хүссэн өргөдөл;*
2. хүүхдийн төрсний гэрчилгээ, хуулбарын хамт;
3. . аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлгийн мэргэжлийн эмч нарын хяналтын комиссын шийдвэр;
4. эрхийн бичгийн үнэ төлсөн баримт эсхүл нэхэмжлэл.